- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль
- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Улсын бүртгэлийн ерөнхий хууль
- Эрүүл мэндийн тухай хууль

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Эрүүл мэндийн газрын хяналт шалгалтын албанаас үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийгдэн санхүүгийн үйл ажиллагаанд аливаа шалгалт хийгдээгүй байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Аргалант сумын Эрүүл мэндийн төв нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурьар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байгаа ба энэхүү баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай нийцээгүй байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Аргалант сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 106,508.2 мянган төгрөгөөр буюу 18.6 хувиар *өссөн* байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 20,416.8 | 28,341.6 | 7,924.8 |
| Авлага | 294.2 | 35,994.4 | 35,700.2 |
| Бараа материал | 99,424.3 | 141,276.5 | 41,852.2 |
| Үндсэн хөрөнгө | 453,507.5 | 474,538.5 | 21,031.0 |
| **Нийт хөрөнгө** | **573,642.8** | **680,151.0** | **106,508.2** |
| Өр төлбөр | 2,797.5 | 20,459.1 | 17,661.6 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 570,845.3 | 659,691.9 | 88,846.6 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **573,642.8** | **680,151.0** | **106,508.2** |

Дээрх хүснэгтээс харахад: Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 7,924.8 мянган төгрөгөөр өссөн Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилт оны эцэст хийгдсэнээс шалтгаалжээ.

Авлага дансны үлдэгдэл 35,994.4 мянган төгрөг болж 35,700.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь Эрүүл мэндийн даатгалын сангаас авах авлага 24,946.3 мянган

төгрөг, ХХОАТ-ын авлага 938.7 мянган төгрөг, НДШ-ийн авлага 9,606.7 мянган төгрөгийн авлага байна. НДШ-ийн авлагын дүнг давхардуулан шилжүүлснээс авлагын дүн нэмэгдсэн байна.

Бараа материал дансны эм боох материал 21,946.1 мянган төгрөг, аж ахуйн материал 1,594.6 мянган төгрөг, бичиг хэргийн материал 512.6 мянган төгрөг, барилгын материал 1,150.0 мянган төгрөг, бусад хангамжийн материал 9,192.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь Төв аймгийн Эрүүл мэндийн газраас 25,462.6 мянган төгрөгийн бусад хангамжийн материал, 11,744.5 мянган төгрөгийн эм боох материал, нийт 20,936.4 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авснаас нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө данс 2023 онд тоног төхөөрөмж 60,113.3 мянган төгрөг, тавилга эд хогшил 13,000.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь тайлант онд улсын төсвийн хөрөнгөөр 1,600.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 13,000.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил худалдан авч, 58,513.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмж үнэ төлбөргүй хүлээн авснаар үндсэн хөрөнгө нэмэгдсэн байна.Төв аймгийн Эрүүл мэндийн газраас 11,840.3 мянган төгрөг, Эрүүл мэндийн яамнаас 46,673.1 мянган төгрөгийн тоног төхөөрөмж үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 659,151.0 мянган төгрөг болж 106,508.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг Эрүүл мэндийн даатгалын сангаас 238,648.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 42,648.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төв аймгийн Аргалант сумын Эрүүл мэндийн төв нь дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 200,225.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 2023 оны урсгал зардлын төсвийг 481,290.3 мянган төгрөгөөр баталж ирүүлсэн байна. Энэ нь Эрүүл мэндийн даатгалын сангаас 438,641.8 мянган төгрөг, орон нутгийн хөгжлийн сангаас 42,648.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөсөн.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 28.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 481,290.3 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 58,082.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс олгожээ.

Тайлант оны батлагдсан төсөв 481,290.3 мянган төгрөгөөс 4 удаа тодотгол хийж 481,290.3 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 478,223.3 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, зарцуулаагүй 1,314.7 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Тайлант хугацааны төсвийн нийт зардлын гүйцэтгэл 478,223.3 мянган төгрөг буюу 89.3 хувьтай байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1. | 71602- Эмнэлгийн тусламж үйлчилгээ | | | | |
| 1.1 | 80111-Төрийн байгууллагуудын тогтмол зардал | 42,648.5 | 41,498.5 | 1,150.0 | 96.6 |
| 1.2 | 80302-Нэг хүнд ногдох нормативаар тооцсон. | 315,893.4 | 298,466.3 | 17,427.1 | 94.4 |
| 1.3 | 81603-Үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ | 122,748.4 | 118,104.5 | 4,643.9 | 96.2 |
| 1.4 | 83603- Нэмэлт дээд шатны төсвөөс хуваарилсан | 20,100.0 | 20,100.0 | | 100.0 |
| | **Дүн** | **481,290.3** | **478,223.3** | **23,385.7** | **89.3** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймгийн Аргалант сумын Эрүүл мэндийн төв нь тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөгөөр нийт 71,544.5 мянган төгрөгийн бараа ажил үйлчилгээ худалдан авахаар төлөвлөсөн. Үүнд: Үүнээс хоол хүнс 4,180.0 мянган төгрөг, бичиг хэрэг 2,250.0 мянган төгрөг, шуудан интернэт 500.0 мянган төгрөг, урсгал засвар 3,000.0 мянган төгрөг, ашиглалтын зардалд 51,064.5 мянган төгрөг, бусад зардалд 10,550.0 мянган төгрөгийг тус бүр шууд худалдан худалдан авахаар төлөвлөсөн. Гүйцэтгэлээр 51,322.5 мянган төгрөгийн бараа үйлчилгээг худалдан авсан байна. Тайлант оны худалдан авахаар захиалсан эм эмнэлгийн хэрэгсэл хугацаандаа нийлүүлэгдээгүйгээс 2022 гэрээг үргэлжлүүлэн худалдан авалт хийсэн.

Энэ нь өр төлбөр үүсэхэд нөлөөлсөн байна. Худалдан авалтын дүн буурсан нь эмчлүүлэгчдийн тоо багассантай холбоотой байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Аргалант сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Өлзийт экаунт аудит” ХХК-ний Аудитор  Ч.Эрдэнэжав гүйцэтгэж, чанарын хяналтыг Чанарын хяналтын менежер Ц.Бямбажав хэрэгжүүлж,  дараагийн шатны хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус  хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Аргалант сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Өлзийт экаунт аудит” ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/02  дугаар албан бичгийн хамт хүргүүлсэн  боловч санхүүгийн тайлангийн залруулгыг хийж баталгаажуулан 03 дугаар сарын 18 өдөр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Төв аймгийн Аргалант сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Аргалант сумын Эрүүл мэндийн төвийн батлагдсан 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлага 438,760.7 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 6,581.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 4,936.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тус эмнэлэг нь тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон зардлууд гараагүй, өглөг үүсгээгүй, төсвийн хөрөнгийг хэмнэлттэй зарцуулан ажилласан байна.   Үүнд: Томилолт 972.4 мянган төгрөг,бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 607.5 мянган төгрөг,  бараа ажил үйлчилгээний бусад зардлыг 5,331.4 мянган төгрөг, нийт 6,911.3 мянган төгрөгийн зардлыг хэмнэсэн байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Аргалант сумын Эрүүл мэндийн төвийн шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад нийт мэдээлбэл зохих 171 мэдээллээс 10 мэдээллийг хугацаа хоцроож, 161 мэдээллийг хуулийн хугацаанд мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

## 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Аргалант сумын Эрүүл мэндийн төвийн эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар 4 зөвлөмж, 4 албан шаардлага өгөгдсөнийг 75 хувь хэрэгжүүлэн, биелэлтийг хүргүүлсэн байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Албан шаардлага | 4 | 515,748.7 | 2 | 490,951.2 | 50% |
| Зөвлөмж | 4 | 37,980.7 | 4 | 37,980.7 | 100% |
| **Нийт дүн** | **8** | **345,723.0** | **6** | **528,931.9** | **75%** |

## 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар тус байгууллагын дараах асуудлуудыг анхаарч үзэх нь зүйтэй байна. Үүнд:

- Төв аймгийн Аргалант сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны зардлын болон эргэлтийн эмийн сангийн цахим төлбөрийн баримтууд татварын цахим системд нэг регистрээр бүртгэгдэж байна. Үүнээс үүдэн эргэлтийн эмийн сангийн орлого, зарлагын гүйлгээний хяналтын тогтолцоо алдагдах эрсдэл үүссэн асуудал,
- Анхан шатны баримт хөтлөлт, ерөнхий журнал, гүйлгээ баланс, тайлангуудын хоорондын уялдаа холбоо, бүртгэлд тавих хяналтыг сайжруулсан эсэх

.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 500,453.3 мянган төгрөгийн алдаа[1] илэрснээс аудитын явцад залруулаа.Үүнд:

Мөнгөн гүйлгээний тайлангийн үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн төсвийн гүйцэтгэлийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн дүнг 427,191.5 мянган төгрөгийн зөрүүтэй илэрхийлэгдсэн.Энэ нь УСНББОУС 1-д "Үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээ, бусад үйл явдал, нөхцөл байдлын үр нөлөөг УСНББОУС-д заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурын дагуу үнэнч шударга илэрхийлэхийг шаарддаг" гэсэн стандартын заалт, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Бараа материалын тодруулга тайлангийн орлогын дүн нь 73,261.6 мянган төгрөгийн зөрүүтэй илэрхийлэгдсэн нь УСНББОУС 1-Санхүүгийн Тайлангийн Толилуулга-Үнэн зөв толилуулга ба УСНББОУС-тай нийцсэн байдал "Үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээ, бусад үйл явдал, нөхцөл байдлын үр нөлөөг УСНББОУС-д заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурын дагуу үнэнч шударга илэрхийлэхийг шаарддаг" гэсэн стандарт, толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Аудитаар нийт 707,819.1 мянган төгрөгийн зөрчил илэрч 2 албан шаардлага, 1 сахилгын шийтгэл ногдуулахаар хүргүүллээ.

### 5.1 Албан шаардлага

**1. Өглөг, авлагатай холбоотой асуудал** Тайлант онд 35,994.4 мянган төгрөгийн авлага, 21,372.0 төгрөгийн өглөг үүсгэж нийт 57,366.5 мянган төгрөгийн зөрчил байна. Энэ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", УСНББОУС-д заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурын дагуу үнэнч шударга илэрхийлэхийг шаарддаг," гэж заасантай нийцээгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль, тогтоомж, гэрээ хэлэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн албан шаардлага хүргүүлэх.

**2. Хөрөнгийн тооллоготой холбоотой асуудал** Тайлант онд нийт 147,313.8 мянган төгрөгийн бараа материалыг, 503,138.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, нийт 650,452.6 мянган төгрөгийн хөрөнгийг тус бүр тоолж баталгаажуулаагүй байна. Энэ нь Улсын секторын

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

байгууллагуудын нийтлэг зорилготой санхүүгийн тайлангийн онолын үзэл баримтлалын 5.20-д "Хуулиар хүлээсэн үүрэг нь хуульд заасны дагуу хүчин төгөлдөр хэрэгждэг. Ийм хууль ёсны хүчин төгөлдөр үүрэг нь янз бүрийн хуулийн илэрхийлэх утгаас үүсэж болох юм”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2-т "Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана, 70.2.1-д "Үндсэн хөрөнгө, дуусаагүй хөрөнгө оруулалт ба барилга угсралтын ажил, их засварын зардлын тооллогыг жилд нэг удаа /12 дугаар сарын 01-нээс 31-ний дотор" 70.2.2-т "Түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс/"” гэж заасантай нийцээгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-д “хууль, тогтоомж, гэрээ хэлэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн албан шаардлага хүргүүлэх.

**5.2 Сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлага**

Тус байгууллагын нягтлан бодогч нь санхүүгийн тайлангаа төсвийн тухай хуулийн цагалбарт хугацаанд бэлтгээгүй, аудитад шаардлагатай нотлох баримтуудыг бүрэн ирүүлж ажиллаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д “төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх” г гэж заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.2-д “Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд "Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага” хүргүүлэв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### 6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Мөнгөн гүйлгээний тайланд Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого дутуу тусгасан | 1 | 427,191.5 | 1 | 427,191.5 | | | | | | | | |
| Өмчийн өөрчлөлтийн тайлангийн эхний үлдэгдлийг зөрүүтэй тайлагнасан. | 1 | 73,261.6 | | | 1 | 73,261.6 | | | | | | |
| **Дүн** | **2** | **500,453.1** | **1** | **427,191.5** | **1** | **73,261.6** | | | | | | |

**6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Өглөг, авлага үүсгэсэн | 1 | 57,366.5 | | | 1 | 57,366.5 | | | | | | |
| Хөрөнгө тоолж баталгаажуулаагүй | 1 | 650,452.6 | | | 1 | 650,452.6 | | | | | | |
| Санхүүгийн тайланг хуулийн хугацаанд бэлтгээгүй | 1 | - | | | | | | | 1 | - | | |
| **Дүн** | **3** | **707,819.1** | | | **2** | **707,819.1** | | | **1** | **-** | | |

# ТӨВ АЙМАГ
# ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
# АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 27 өдөр Дугаар 108-17225502-ТӨА-2024/213/НА-СТА-ТШ3 Зуунмод

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Аргалант сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд нийт 147,313,768.75 төгрөгийн бараа материал, 503,138,877.93 төгрөгийн үндсэн хөрөнгө нийт 650,452,646.68 төгрөгийн бараа материал, үндсэн хөрөнгийг тус бүр тоолж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2-т "Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана, 70.2.1-д "Үндсэн хөрөнгө, дуусаагүй хөрөнгө оруулалт ба барилга угсралтын ажил, их засварын зардлын тооллогыг жилд нэг удаа /12 дугаар сарын 01-нээс 31-ний дотор", 70.2.2-т "Түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс/" гэж заасныг, Санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.2-д "хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу тооллогыг иж бүрэн хийж, тооллогын бүртгэлийг нэгтгэн илтгэх хуудас, үр дүнг тооцон ажиллах, албан шаардлагын биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг

[1]Төв аймаг, Зуунмод сум, 6 дугаар байр, Төр захиргааны 2 дугаар байр 105 тоот Утас: 70272582

0190404[illegible]

хэрэгжүүлж ажиллахыг Төв аймгийн Аргалант сумын Эрүүл мэндийн төвийн дарга М.Пүрэвжав, нягтлан бодогч Б.Билэгсайхан нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ХИШИГЖАРГАЛ

ӨЛЗИЙТ ЭКАУНТ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ч.ЭРДЭНЭЖАВ

ТӨВ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 25 өдөр Дугаар 122-17225502-ТӨА-2024/213/НА-СТА-ТШ3 Зуунмод

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Аргалант сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд нийт 35,994,430.33 төгрөгийн авлага, 21,372,091.22 төгрөгийн өглөг нийт 57,366,521.55 төгрөгийн авлага, өглөг үүсгэж ажилласан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг, санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль, тогтоомж, гэрээ хэлэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Авлага, өр, төлбөрийг барагдуулан ажиллах, дээрх зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

[1]Төв аймаг, Зуунмод сум, 6 дугаар байр, Төр захиргааны 2 дугаар байр 105 тоот Утас: 70272582

019040534

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төв аймгийн Аргалант сумын Эрүүл мэндийн төвийн дарга М.Пүрэвжав, нягтлан бодогч Б.Билэгсайхан нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ХИШИГЖАРГАЛ

ӨЛЗИЙТ ЭКАУНТ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ч.ЭРДЭНЭЖАВ

# ТӨВ АЙМАГ
# ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
# АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 27 өдөр Дугаар 94-17225502-ТӨА-2024/213/НА-СТА-ТШ3 Зуунмод

**Сахилгын хариуцлага тооцуулах тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Аргалант сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллагын нягтлан бодогч нь санхүүгийн тайлангаа төсвийн тухай хуулийн цагалбарт хугацаанд бэлтгээгүй, аудитад шаардлагатай нотлох баримтуудыг бүрэн ирүүлж ажиллаагүй байна.

Энэ Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д "төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх" гэж заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалаас чөлөөлөх талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.2-д "Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд "Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага" хүргүүлнэ гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Зөрчил гаргасан нягтлан бодогч Б.Билэгсайханд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

---

[1]Төв аймаг, Зуунмод сум, 6 дугаар байр, Төр захиргааны 2 дугаар байр 105 тоот Утас: 70272582

019040414

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төв аймгийн Аргалант сумын Эрүүл мэндийн төвийн дарга М.Пүрэвжав, нягтлан бодогч Б.Билэгсайхан нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ХИШИГЖАРГАЛ

ӨЛЗИЙТ ЭКАУНТ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ч.ЭРДЭНЭЖАВ